



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА  
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

# COVID-19

## БИЗНЕС ДЭХ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГААНУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАН

- ▶ БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА
- ▶ ТҮРЭЭСИЙН БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА
- ▶ АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА
- ▶ НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН 2020 ОНЫ ХАНДЛАГА
- ▶ ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА

## **ӨМНӨХ ҮГ**

МҮХАҮТ нь бизнесийн орчны өөрчлөлт, түүний үр нөлөөг байнга анхаарч судлах, бодлогын судалгаануудыг тогтмол явуулах, судалгааны үр дүнд үндэслэн санал зөвлөмж боловсруулан бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт хүргэх чиг үүргийг хүлээдэг.

Энэ чиг үүргийнхээ хүрээнд МҮХАҮТ-аас вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх хорио цээрийн арга хэмжээ

авсан цагаас бизнест үзүүлж буй нөлөөний судалгааг явуулж, судалгааны үр дүнд үндэслэн “Эдийн засгийн эрсдэлийг удирдах багц санал”-ыг боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон гол Яамдын сайд нарт танилцуулсан билээ. Мөн ажлын байранд болон зарим салбарт үзүүлж байгаа нөлөөлөл, учирч болох эрсдэл, шаардлагатай арга хэмжээний талаар судалгаануудыг явуулж үр дүнг цаг тухайд нь мэдээлсэн.

Covid-19 вирусийн халдвар дэлхий нийтэд эрчимтэй тархаж цар тахлын хэмжээнд хүрснээс шалтгаалан дэлхийн эдийн засаг, түүний дотор томоохон эдийн засагтай орнуудын эдийн засгийн өсөлт огцом буурах хандлагатай болсон нь дэлхий даяарчлагдаж, эдийн засаг, нийлүүлэлтийн сүлжээний харилцан хамаарал өмнөхөөс илүү болсон энэ үед эдийн засгийн ноцтой хямрал тулгарах таамаглалыг олон улсын байгууллагууд, эдийн засагчид, судлаачид дэвшүүлж байна.

Иймд МҮХАҮТ-аас вирусийн халдвараас шалтгаалан үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор 3-р сард явуулсан судалгааны тайлангуудыг нэгтгэн Та бүхэнд толилуулж байна. Энэхүү тайлан нь эдийн засаг бизнесийн хувьд учирч болох эрсдэлийг удирдах бууруулах, жижиг дунд бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг хадгалах чиглэлээр зөв оновчтой шийдвэр гаргахад тань тус дэм болно гэдэгт итгэлтэй байна.

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ**

## **АГУУЛГА**

1. БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА .....	2
2. ТҮРЭЭСИЙН БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА.....	10
3. АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА .....	15
4. НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН 2020 ОНЫ ХАНДЛАГА.....	24
5. ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА .....	31

## **БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА**

- Хураангуй
- Бизнес үзүүлж буй нөлөө
- Шаардлагатай дэмжлэгүүд
- Оролцогсдын мэдээлэл

**2020 оны 3 дугаар сарын 5**



## ХУРААНГУЙ

БНХАУ-д гарсан шинэ корона вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бизнест үзүүлж байгаа үр нөлөө, бизнес эрхлэгчдэд шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг 2020 оны 3 сарын 3-4 өдрүүдэд 1100 аж ахуйн нэгжийг хамруулан явуулсан.

Судалгаанд оролцогсдын 67% нь Улаанбаатар хот, 33% нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ба үйл ажиллагааны авч үзвэл 25% нь худалдаа, 22% нь үйлчилгээ, 11% нь хүнсний үйлдвэрлэлийн салбар байна. Нийт судалгаанд оролцсон ААН-үүдийн 89% нь жилийн 5 тэрбумаас жилийн орлоготой, 92% нь 199 хүртэлх ажиллагсадтай, 48% нь 10-аас дээш жил, 24% нь 5-10 жил үйл ажиллагаагаа явуулж байна.

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ 89.5% нь маш их ба дунд түвшинд нөлөөлсөн байгаа бол дөнгөж 2.2% нь нөлөөлөөгүй байна. Бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодруулан асуухад 57.7% нь бараа үйлчилгээний эрэлт буурсан, 40.1% нь тээвэр ложистик доголдсоноос бараа үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон нь гэж хариулжээ. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бизнест үүсээд буй хүндрэлийг нээлттэй асуулгаар асуухад зээлийн эргэн төлөлт, НДШ-ын төлбөр, түрээсийн төлбөр гэсэн асуудлуудыг хамгийн их хүндрэл учруулж байна гэж нэрлэсэн байна.

Сэргийлэх арга хэмжээ нь 2020 оны эхний хагас жилийн тухайн компанийн орлогод хэрхэн нөлөөлөх талаар 67.4% нь орлого 10-аас дээш хувиар, 46.4% нь орлого 30 ба түүнээс дээш хэмжээгээр буурна гэж үзжээ. 2020 оны бизнесийн төлөвлөсөн зорилгодоо өөрчлөлт оруулах эсэхийг асуухад 32.9% нь одоогоор дүгнэхэд эрт байна гэж үзсэн бол 31.1% нь зорилгоо бага хэмжээгээр бууруулна гэж хариулжээ.


Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг тодруулан асуухад судалгаанд оролцогсдын 42.6% нь түрээсийн төлбөр бууруулах гэх мэт аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээ, 36.3% нь ААН-ын татвар, НДШ-ийг хойшлуулах, 20.3% нь хориг цуцлагдсаны дараа бизнесийг сэргээж үйл ажиллагааг хэвийн явуулахад төрөөс нэгдсэн зохицуулалтаар ханган төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай явуулах нь зүйтэй гэж үзжээ. Мөн аж ахуйн нэгжийн зээлийг төрөөс бодлогоор зохицуулах, төрийн худалдан худалдан авалтад ЖДҮ-г дэмжих, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай үзүүлэх иргэдийн хэрэглээ, худалдан авах чадварыг нэмэгдүүлэн эдийн засгийг идэвхжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.

## БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

COVID-19 вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ бизнест нөлөөлсөн тухай тодруулан асуухад судалгаанд оролцогсдын 57.4% нь маш их нөлөөлсөн, 32% нь дунд зэрэг нөлөөлсөн гэж хариулжээ. Харин 8.3% нь одоо хэлэхэд эрт байна гэж үзсэн бол дөнгөж 2% нь ямар нэг нөлөөгүй байна гэж хариулжээ.



Энэ үзүүлэлтийг салбараар ангилан харвал боловсрол, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, эрүүл мэнд, үйлчилгээ, барилгын салбарын бизнес эрхлэгчдэд хамгийн их нөлөөтэй ба дунджаар 96% нь үйл ажиллагаанд дунд ба маш их хэмжээгээр нөлөөлсөн гэж хариулсан байна. Харин тээвэр, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн бизнест дунджаар 69% нь нөлөөлсөн гэж хариулжээ. Гэвч нийт дүнгээр нь харвал бүх салбарын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд 65%-аас дээш дүнгээр нөлөө үзүүлжээ.




Ямар нөлөө үзүүлсэн талаар тодруулан асуухад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 57.7% нь бараа үйлчилгээний эрэлт буурсан, 40% нь тээвэр ложистик доголдсоноос бараа үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон нөлөөлөл хамгийн их байна гэж хариулжээ. Мөн 14.8 хувь нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхойгүй байдал үүссэн ба шийдвэр гаргах... Бэлэн мөнгөний (эргэлтийн хөрөнгийн) хомсдолд орсон 14.5% хувь нь түүхий эдийн нийлүүлэлт доголдсоноос үйлдвэрлэл тасалдсан 8.8% хувь нь ажилтнуудыг түр болон бүрмөсөн чөлөөлсөн 4.0% хувь нь бараа/үйлчилгээний эрэлт нэмэгдсэн 3.0% хувь нь хүний нөөцтэй холбогдох зардал өссөн (хамгаалах хэрэгслээр хангах г.м) 2.5% хувь нь хүний нөөцийн хомсдолд орсон 0.8% хувь нь...


### Covid-19-ээс сэргийлэх арга хэмжээ нь танай бизнест одоогоор ямар нөлөө үзүүлээд байна вэ?



Бизнесийн салбараар ангилан харвал салбарын ялгаагүйгээр бараа үйлчилгээний эрэлт буурсан, тээвэр, ложистик доголдсоноос бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон зэрэг нь хамгийн их нөлөөтэй байна гэж үзсэн байна. Мөн уул уурхайн салбарын хувьд тээвэр, ложистик хамгийн их нөлөөг үзүүлж байгаа бол боловсролын салбарт ажилтнуудыг түр болон бүр мөсөн чөлөөлсөн нь үйл ажиллагаанд ихээр нөлөөлжээ.




### Та 2020 оны бизнесийн хүрэхээр төлөвлөсөн зорилтоо өөрчлөх үү?




### Орлогод үзүүлж буй нөлөө

Сэргийлэх арга хэмжээ нь 2020 оны эхний хагас жилийн тухай компанийн орлогод хэрхэн нөлөөлж байгаа талаар асуухад 46.4% “орлого 30 ба түүнээс дээш хэмжээгээр буурна”, 23.5% одоо хэлэхэд эрт байна, 21% нь орлого 10-30%-иар буурна, 6.3% нь 10% хүртэл хэмжээгээр буурна гэж үзсэн бол дөнгөж 3% нь нөлөөгүй байна гэжээ.

### Covid-19-ээс сэргийлэх арга хэмжээ нь 2020 оны эхний хагас жилд танай компаний орлогод хэрхэн нөлөөлөхөөр байна вэ?




Орлогын нөлөөг салбараар тодруулан авч үзвэл аялал жуулчлал, боловсрол, тээвэр, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, хүнсний үйлдвэрлэлүүдийн салбарын бизнес эрхлэгчдийн 55% нь орлогын хэмжээ 30% ба түүнээс дээш хэмжээгээр буурна гэж үзжээ.



### Бизнес тулгарч байгаа хүндрэл

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бизнест үүсээд буй хүндрэлийг нээлттэй асуулгаар тодруулан асуухад судалгаанд оролцогсдын 66% нь зээлийн эргэн төлөлт, зээлийн хугацаа, зээлийн хүү нь хамгийн их хүндрэлийг бий болгож байна гэж хариулжээ. Мөн 22% нь түрээсийн төлбөр, 9% нь төрийн үйлчилгээ (мэргэжлийн зөвлөлүүдийн хурал, гадаад худалдаа, зөвшөөрөлтэй холбогдох)-ний хүнд суртал, 3 хувь нь санхүүгийн эх үүсвэр бага байгаа нь хүндрэл учруулж байна гэжээ.



## ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГҮҮД

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгааг тодруулан асуухад судалгаанд оролцогсдын 42.6% нь түрээсийн төлбөр бууруулах зэрэг үйл ажиллагааны зардал бууруулах арга хэмжээ, 36.3% хувь нь ААН-ын татвар, НДШ-ыг хойшлуулах, 20.3% нь хориг цуцлагдсаны дараа бизнесийг сэргээж хэвийн үйл ажиллагаа явуулахад нэгдсэн зохицуулалтаар ханган төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай явуулах нь зүйтэй гэж үзжээ.




Шаардлагатай дэмжлэгүүдийг бизнесийн салбараар ангилан авч үзвэл эрүүл мэнд, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, аялал жуулчлалын салбаруудад хориг цуцалсны дараа бизнесийг хэвийн явуулахад төрөөс нэгдсэн зохицуулалт хийж, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй түргэн шуурхай үзүүлэх нь хамгийн чухал гэж үзжээ. Харин уул уурхай, боловсрол, мэдээлэл технологи, харилцаа холбооны салбар салбарт ААН-ын татвар, НДШ-г хойшлуулах нь хамгийн чухал дэмжлэг болно гэж үзжээ. Мөн дэмжих арга хэмжээний талаар нээлттэй асуулгаар асуухад аж ахуйн нэгжийн зээлийн төлөлт, хүүний талаар төрөөс нэгдсэн бодлогоор зохицуулах, төрийн худалдан худалдан авалтад ЖДҮ-г дэмжих, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай үзүүлэх, иргэдийн хэрэглээ, худалдан авах чадварыг нэмэгдүүлэн эдийн засгийг идэвхжүүлэх зэрэг нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.

Нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 24 хувь нь вирусээс сэргийлэх чиглэлээр ЗГ-т дэмжлэг үзүүлжээ. Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааг тодруулан асуухад 36 хувь нь санхүүгийн дэмжлэг, 29 хувь нь эмнэлгийн тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл, 8 хувь нь тээвэр логистикийн дэмжлэг, 6 хувь нь бизнесийн зөвлөгөө өгсөн байна.



## ОРОЛЦОГСДЫН МЭДЭЭЛЭЛ

Covid-19 вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бизнест үзүүлж байгаа үр нөлөө ба шаардагдаж буй дэмжлэгийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг 2020 оны 3 сарын 3 өдөр явуулж, МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус 601 аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгаанд оролцогсдын 67% нь Улаанбаатар хот, 33% нь орон нутгийн бизнес эрхлэгчид байна.



Судалгаанд оролцсон компаниудын 25% нь худалдаа, 22% нь үйлчилгээ, 11% нь хүнсний үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгжүүд байна. Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 60% нь 500 сая-с доош жилийн орлоготой, 29% нь 1-5 тэрбумын орлоготой байна. Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 61% нь 19 хүртэлх ажилтантай, 31% нь 20-199 ажилтантай аж ахуйн нэгжүүд байна. Нийт аж ахуйн нэгжүүдийн 48% нь 10-с дээш жил үйл ажиллагаагаа явуулсан, 24 % нь 5-10 жил үйл ажиллагаагаа явуулсан бол, 24% нь 1-5 жил үйл ажиллагаа явуулжээ. Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 36% нь 100 сая-с доош жилийн орлоготой, 24 % нь 101-500 сая төгрөгийн орлоготой байна.

## **ТҮРЭЭСИЙН БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА**

- Хураангуй
- Түрээсийн бизнест үзүүлж буй нөлөө
- Шаардлагатай дэмжлэгүүд

**2020 оны 3 дугаар сарын 6**



## ХУРААНГУЙ

МҮХАҮТ-аас шинэ коронавирусийн халдвараас үүдэн үүссэн нөхцөл байдалд бизнес эрхлэгчдэд тулгарч асуудал, шаардагдах дэмжлэгийг тодорхойлох зорилгоор 2020 оны 3 сарын 3-4-ний өдрүүдэд явуулсан үр нөлөөний судалгааны үр дүнгээс үзэхэд түрээсийн төлбөр нь тулгамдаж буй асуудлуудын нэг гэж гарсан. Иймд түрээслүүлэгчдийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулж, уулзалтын үеэр 30 гаруй аж ахуйн нэгжээс асуумжаар судалгаа авч, үр дүнг танилцуулж байна.

Судалгаанд оролцогчдын 41 хувь нь худалдаа, 41 хувь нь үйлчилгээ, 12 хувь нь барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жилийн орлого нь 23 хувь нь 500 сая хүртэл, 38 хувь нь 501 саяас 1 тэрбум хүртэл, 23 хувь нь 1 тэрбумаас дээш төгрөг байна. Тэдгээрийн 68 хувь нь 200 хүртэл, 12 хувь нь 200-иас дээш ажилтантай ба 31 хувь нь 5 жил хүртэл, 59 хувь нь 10-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байна. Судалгаанд оролцсон ААН-үүдийн 38 хувь нь худалдаа, 30 хувь нь үйлчилгээ, 32 хувь нь оффисийн зориулалтаар түрээсийн үйлчилгээ үзүүлдэг байна.

Түрээсийн бизнест үзүүлж байгаа вирусийн халдварын эсрэг хэрэгжүүлж байгаа хориг хязгаарлалтын нөлөөний талаар асуухад 47 хувь нь маш их, 30 хувь нь дунд зэрэг нөлөөлсөн, 23 хувь нь одоо хэлэхэд эрт байна гэсэн ба 52 хувь нь 2020 оны эхний хагас жилийн орлого 30%-аас хэмжээгээр буурна, 24 хувь нь 10-30%-аар буурна гэж үзжээ.


Түрээслэгч аж ахуйн нэгжүүдээс тавьж байгаа хүсэлтийг тодруулан асуухад 24 хувь нь түрээсийн төлбөрөөс бүрэн чөлөөлөх, 52 хувь нь 30%-аас дээш түрээсийн төлбөрийг чөлөөлж өгөх асуудлыг тавьсан байна. Түрээслэгч ААН-үүдэд дэмжлэг үзүүлснээр түрээслүүлэгч ААН-үүдийн 39% нь зээлийн төлбөр, хүүтэй холбогдох хүндрэл үүснэ, 34% нь цахилгаан, дулааны төлбөр зэрэг ашиглалтын зардлуудыг төлөхөд асуудал үүснэ гэжээ.

Судалгааны дүн болон уулзалтын үеэр гаргасан саналуудыг авч үзвэл түрээслэгчдэд хөнгөлөлт үзүүлэхэд түрээслүүлэгч ААН-үүдийн хувьд дараах дэмжлэгүүд шаардлагатай байна. Үүнд:


1. Түрээслүүлэгч ААН-үүдийн орлогын албан татварын төлөлтийг тодорхой хугацаагаар хойшлуулах
2. Түрээсийг төлбөрөө буулгасан түрээсийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд ноогдуулах татварыг нэг удаад чөлөөлж өгөхөөр Засгийн газраас гаргасан шийдвэрийн талаар тодорхой болгох
3. Хорио цээрийн хугацаанд ААН-үүдийг НӨАТ-аас чөлөөлөх
4. НДШ-ийн төлөлтийг 3 сараас доошгүй хугацаагаар хойшлуулах
5. Цахилгаан, дулааны үнэ нэмэгдсэн ч ихэнх ААН-үүд түрээсийн зардлыг нэмээгүй байна. Иймд төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд төлдөг цахилгаан, дулаан зэрэг ашиглалтын зардлуудыг тодорхой хувиар бууруулах
5. Газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвараас тодорхой хувиар бууруулах, чөлөөлөх. Газрын төлбөр өссөнөөс өмнө нь 97 сая төгрөг төлдөг байсан аж ахуйн нэгж 300 сая төгрөг төлдөг болж энэ зардал 3 дахин нэмэгдсэн байна.
6. Бусад ААН-үүдийн адил үндсэн зээлийн төлөлтийг хойшлуулах, торгууль, алданги тооцохгүй байх, зээлийн бүтцийг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулахаас гадна, зээлийн бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай байна.

## ТҮРЭЭСИЙН БИЗНЕСТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ


COVID-19 вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээний түрээсийн бизнест үзүүлж байгаа нөлөөний талаар судалгаанд оролцсон түрээслүүлэгчдийн 47 хувь нь маш их нөлөөлсөн, 30 хувь нь дунд зэрэг нөлөөлсөн, 23 хувь нь одоо хэлэхэд эрт байна гэж үзсэн.



2020 оны эхний хагас жилд орлогод үзүүлэх нөлөөний талаар түрээслүүлэгчдийн 52 хувь нь орлого 30% ба түүнээс дээш хэмжээгээр буурна, 24 хувь нь 10-30%-аар, 6 хувь нь 10% хүртэл буурна гэсэн бол 18 хувь нь одоо хэлэхэд эрт байна гэж үзжээ.




2-р сард 50 хувь нь түрээсийн орлого 10-30%-аар, 28 хувь нь орлого 30% ба түүнээс дээш хэмжээгээр буурсан гэсэн бол 18 хувь нь өөрчлөгдөөгүй гэсэн байна.




### Түрээсийн төлбөр

Түрээслэгчдээс түрээслүүлэгч ААН-үүдэд тавьж байгаа гол шаардлага нь түрээсийн төлбөрийн хөнгөлөх чөлөөлөх асуудал байна. Түрээслэгчдийн 19 хувь нь түрээсийн төлбөрийг 30% хүртэл, 34 хувь нь 30-50%-аар, 18 хувь нь 50%-аас дээш хэмжээгээр чөлөөлөх гэсэн бол 24 хувь нь түрээсийн төлбөрөөс бүрэн чөлөөлөх, 5 хувь нь түрээсийн төлбөрийг хойшлуулах хүсэлтийг ирүүлсэн байна.




Одоогийн байдлаар түрээслүүлэгчдийн 64 хувь нь түрээсийн төлбөрөөс тодорхой хувиар хөнгөлөлт үзүүлж байгаа, 23 хувь нь түрээсийн төлбөртэй холбогдох торгууль алдангиас чөлөөлөх, 13 хувь нь түрээсийн төлбөрийг хойшлуулах байдлаар түрээсийн төлбөрт тодорхой хөнгөлөлт үзүүлж байна гэсэн.



### ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ

Цаашид түрээслэгчдэд илүү хөнгөлөлт үзүүлэхэд түрээслүүлэгч ААН-үүдэд Засгийн газраас хүсч байгаа дэмжлэгийн хувьд 40 хувь нь ААН-ийн орлогын албан татварыг чөлөөлөх, зээлийн төлөлтийг хойшлуулах талаар хууль эрх зүй, журмуудад өөрчлөлт оруулах, 31 хувь нь ААН-ийн татварыг хойшлуулах, 20 хувь нь НДШ-ийг хойшлуулах, 6 хувь нь бусад, тухайлбал НӨАТ-ыг бууруулах, ашиглалтын зардал бууруулах ба зээлийн төлөлтийг хойшлуулах гэж хариулсан байна.



## **АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА**

- Хураангуй
- Ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөө
- Шаардлагатай дэмжлэгүүд
- Оролцогсдын мэдээлэл

**2020 оны 3 дугаар сарын 24**

## ХУРААНГУЙ

Covid-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээний ажлын байранд үзүүлж байгаа үр нөлөө ба шаардагдаж буй дэмжлэгийг тодорхойлох зорилгоор 2020 оны 3 сарын 20-23 өдрүүдэд МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус 1504 аж ахуйн нэгжийг хамруулан судалгаа явуулсан. Судалгаанд оролцсон ААН-үүдийг салбараар харвал 19% нь худалдаа, 15% нь үйлчилгээ, 13% нь аялал жуулчлал, 9% нь хүнсний үйлдвэрлэл, 6% нь хөнгөн үйлдвэрлэл ба 40% нь бичил, 39% нь жижиг дунд, 21% нь том аж ахуй нэгж бөгөөд 51% нь 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулсан байна.

Судалгаанд оролцсон нийт ААН-үүдийн 67.4% нь Covid-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээ маш их, 22.8% нь дунд зэрэг нөлөөлсөн байна. Салбараар авч үзвэл, аялал жуулчлалын салбарын 90%, зочид буудал, нийтийн хоолны салбарын 83%-д маш их нөлөөлсөн бол энэ үзүүлэлт хөдөө аж ахуйн салбарт 40%, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт 33% байна.

Үүссэн нөхцөлд байдалд ААН-үүдийн 56% нь ажлын цагийн зохицуулалт хийсэн, 33% нь ажиллагсдаа түр болон бүр чөлөөлсөн байна. Ажиллагсдыг чөлөөлсөн байдлыг салбараар үзвэл зочид буудал, нийтийн хоолны 52%, аялал жуулчлалын салбарын 44% байна. Харин мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын 12% нь ажиллагсдаа чөлөөлсөн бол эрчим хүчний салбарын хувьд ажлын байрны тоо өөрчлөгдөөгүй байна.

Судалгаанд оролцсон ААН-үүдийн 65% нь өндөржүүлсэн бэлэн байдлын шийдвэрээс шалтгаалж, 41% нь үйлдвэрлэл үйлчилгээ буурсантай холбоотойгоор ажлын цаг, ажиллах хэлбэрт тодорхой өөрчлөлт оруулсан байна. Эдгээрийн 46% нь богиносгосон цагт шилжүүлсэн, 35% нь зайнаас ажиллуулсан, 16% нь ямар нэг өөрчлөлт оруулаагүй байна. Цалин хөлсийн хувьд 63% нь өөрчлөлт оруулаагүй, 36% нь бууруулсан гэжээ.

Ажлын байрыг хадгалахад тулгарч байгаа асуудалд 65% нь орлого буурсан, 42% нь үйл ажиллагаа зогссон, 30% зардлаа бууруулах шаардлагатай болсон гэж хариулсан байна. Худалдаа, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудад орлого буурсан нь ажлын байрыг хадгалахад хүндрэл үүсгээд байгаа бол боловсрол, аялал жуулчлал, зочид буудал нийтийн хоолны салбаруудад үйл ажиллагаа зогссон доголдсоноос шалтгаалан илүү хүндрэл болж байна. Одоогийн байдлаар судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 33% нь ойролцоогоор 6000 ажлын байрыг түр болон бүр хугацаагаар цөөлсөн дүнтэй байна.


2020 оны 2-р улиралд үүссэн нөхцөл байдал үргэлжилсэн тохиолдолд судалгаанд оролцсон ААН-үүдийн 30% нь нийт 8000 орчим тооны ажлын байрыг цомхтгох төлөвлөгөөтэй гэсэн бол зөвхөн 12% ажлын байраа хэвээр хадгална гэсэн байна. Харин ААН-үүдийн 68% нь одоо хэлэхэд эрт байна, мэдэхгүй гэж хариулжээ. Салбараар авч үзвэл, хөнгөн үйлдвэрлэл, зочид буудал нийтийн хоол, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарт илүү ажлын байрны цомхтгол явуулахаар байна.

Ажлын байрыг хадгалж үлдэхэд ажиллагчдын тооны бүлэг, бизнесийн салбар харгалзахгүйгээр хамгийн чухал дэмжлэг нь төрөөс ажлын байрыг хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна гэж үзсэн байна. Мөн хөнгөлөлттэй зээл, Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн хугацааг хойшлуулах нь ажлын байрыг хадгалахад дэмжлэг болно гэж үзжээ.


## АЖИЛ ЭРХЛЭЛТЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

### Бизнес дэх нөлөө

Covid-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээ нөлөөний талаар судалгаанд оролцогсдын 67.4% нь маш их, 22.8% нь дунд зэрэг нөлөөлсөн, 7.6% нь одоо хэлэхэд эрт байна, 2.2% нь нөлөөлөөгүй гэж хариулсан.



Бизнест үзүүлсэн нөлөөг салбараар авч үзвэл, аялал жуулчлалын салбарын 90%, зочид буудал, нийтийн хоолны 83%, тээврийн 73%, хөнгөн үйлдвэрлэлийн 71%, үйлчилгээний 70%, худалдааны салбарын 66%-д нь маш ихээр нөлөөлсөн гэжээ.



## Ажлын байрны тооны өөрчлөлт


Судалгаанд оролцогсдын 66% нь ажлын байрны тоонд ямар нэг өөрчлөлт оруулаагүй бол 33% нь ажиллагсдаа түр хугацаагаар болон бүрмөсөн чөлөөлсөн байна. Ажлын байрны тооны өөрчлөлтийг салбараар харвал зочид буудал, нийтийн хоолны 52%, аялал жуулчлалын 44%, банк санхүүгийн 42%, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 39% нь ажлын байрны тоог бууруулжээ. Одоогийн байдлаар нийтдээ **6000** орчмоор ажлын байрны тоо буурсан байна.



## Ажлын цаг, ажиллах хэлбэр

Судалгаанд оролцогсдын 56% нь ажлын цагийн зохицуулалт хийх, 47% нь эрүүл мэндийн хамгаалалтын хэрэгслээр хангах байдлаар ажилтнууддаа чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн бол 36% нь ариун цэвэр халдвар хамгаалалтын сургалт хийсэн байна.

Судалгаанд оролцсон ААН-үүдийн 46% нь богиносгосон цагаар, 35% нь зайнаас ажиллуулах байдлаар ажлын цаг, ажиллах хэлбэрт өөрчлөлт оруулсан бол 28% нь ээлжийн амралтыг өгч амраасан ба 16% нь ямар нэг өөрчлөлт оруулаагүй байна.






Ажлын цаг, ажиллах хэлбэрийг өөрчлөх шалтгаан нь 65% нь өндөржүүлсэн бэлэн байдлын шийдвэр, 41% нь үйлдвэрлэл, үйлчилгээний тоо буурсан явдал гэж хариулсан байна. ААН-үүдийн 63% нь цалин хөлсийг өөрчлөөгүй, 36% нь бууруулсан бол дөнгөж 1% нь нэмэгдүүлсэн байна.

### Ажлын байрыг хадгалах


Ажлын байраа хадгалж үлдэхэд тулгарч байгаа асуудлаар судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн 65% нь орлого буурсан, 42% үйл ажиллагаа зогссон, доголдсон, 30% нь зардлаа бууруулах шаардлагатай болсон зэрэг нь хүндрэл, бэрхшээл үүсгэж байна гэжээ.



Салбараар нарийвчлан авч үзвэл, судалгаанд оролцсон худалдаа эрхэлдэг ААН-ийн 47%, хөнгөн үйлдвэрлэлийн 41%, хүнсний үйлдвэрлэлийн 42% нь орлого буурсан нь ажлын байрыг хадгалахад хүндрэл үүсгэж байна гэсэн бол боловсролын 46%, зочид буудал нийтийн хоолны 30%, үйлчилгээний салбарын 29% нь үйл ажиллагаагаа зогсоосноос шалтгаалж байна гэжээ.



Covid-19 вирусийн тархалт, халдвараас шалтгаалан учирч буй хүндрэл нь 2-р улиралд үргэлжилсэн тохиолдолд 30% нь ажлын байрны цомхтгол явуулна, 12% нь өөрчлөхгүй гэж үзсэн бол 45.2% нь одоо таамаглан хэлэхэд эрт байна, 12.7% нь мэдэхгүй гэсэн байна.




Ажлын байрны цомхтгол хийхээр төлөвлөсөн тоог асуухад 29% нь 20 хүртэлх, 5% нь 21-50 тооны, 2% нь 51-ээс дээш тооны ажлын байраа бууруулна гэж үзсэн ба ойролцоогоор 8000 орчим ажлын байрыг цомхтгохоор байна.

Ажлын байрыг цомхтгоно гэсэн хариултыг судалгаанд оролцсон аж ахуй нэгжүүдийн салбараар авч үзвэл хөнгөн үйлдвэрлэлийн 50%, зочид буудал, нийтийн хоолны 43%, үйлчилгээний 38%, аялал жуулчлалын салбарын 38%-ийг тус тус эзэлж байна.



## АЖЛЫН БАЙРЫГ ХАДГАЛАХАД ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ

Судалгаанд оролцсон ААН-үүдийн 63% нь ажлын байр хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг, 49% нь НДШ-ийн төлбөрийн төлөх хугацааг хойшлуулах, 44% нь хөнгөлөлттэй зээл олгох зэрэг нь ажлын байрыг хадгалахад төрөөс нэн тэргүүнд үзүүлэх шаардлагатай дэмжлэг гэж үзжээ.



Дээрх шаардлагатай дэмжлэгүүдийг салбараар харвал уул уурхайн 44%, банк санхүүгийн 42%, үйлчилгээний 42%, тээврийн салбарын 41% нь ажлын байр хадгалан үлдэхэд зориулсан санхүүгийн дэмжлэг шаардлагатай гэж үзсэн бол, хөдөө аж ахуйн салбарын 38%, хүнсний үйлдвэрлэлийн салбарын 30% нь хөнгөлөлттэй зээл хэрэгцээтэй байна гэжээ. Мөн

хөнгөн үйлдвэрлэлийн салбарын 32%, үйлчилгээ, тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, аялал жуулчлалын 33%, барилгын 38%, боловсролын салбарын 36% нь НДШ-ийн төлбөрийг төлөх хугацааг хойшлуулах нь бодитой дэмжлэг болно гэж үзжээ.



Ажиллагсдын тооны бүлгийн ялгаагүйгээр хамгийн чухал дэмжлэг нь төрөөс ажлын байрыг хадгалахад зориулсан санхүүгийн дэмжлэг гэж үзсэн байна. Мөн бусад дэмжлэгийн хувьд 10 хүртэлх ажилтантай ААН-үүдийн хувьд хөнгөлөлттэй зээл чухал бол 50-200 ажилтантай аж ахуйн нэгжүүдийн хувьд НДШ-ийн төлбөрийг хойшлуулах нь илүү чухал байна. Үл хөдлөх, эд хөрөнгийн татвар, НӨАТ(10%)-аас хөнгөлөх нь мөн чухал болохыг дурджээ.

Ажлын байрыг хадгалахад төрөөс үзүүлэх шаардлагатай бусад дэмжлэг гэсэн нээлттэй асуултад зээлийн төлбөрийн асуудлаар Засгийн газар Монголбанкны хамтарсан шийдвэр гаргах, түүнийг бодитой хэрэгжүүлэх; түрээсийн зардлыг бууруулах талаар талууд нэгдсэн шийдэл гаргах, хэрэгжүүлэх; цахилгаан, дулааны төлбөрөөс хөнгөлөх; хорио цээрийн үед бизнесийн зохицуулалт, тусгай зөвшөөрөл, төрийн худалдан авалтын шаардлагыг бууруулах, бизнест үзүүлэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай болгох гэж олон ААН хариулсан байна.

Түүчлэн засгийн газрын хөрөнгө оруулалтыг оновчтой болгох; гадаад худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн олон улсын тээврийн хуваарийг тодорхой болгох; 2020 онд гадаадын жуулчдад визийн хөнгөлөлт үзүүлэх, хорио цээрийн дараа 8-10 саруудад жуулчдын визийг нисэх буудал дээр олгох; төрийн байгууллагын худалдан авалтыг импортыг орлох дотоодын бараа бүтээгдэхүүнээс хийх; ургац хураах үеэр аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; хорио цээрийн дэглэмийг тодорхой түвшинд сулруулах шаардлага байна гэж цөөн тооны оролцогчид үзсэн байна.

## ОРОЛЦОГСДЫН МЭДЭЭЛЭЛ


Судалгааг Улаанбаатар хот, орон нутгийн бизнес эрхлэгчдийн дунд онлайн хэлбэрээр 2020 оны 3 сарын 20-23 өдрүүдэд МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус 1504 аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулж үр дүнг нэгтгэлээ.

Нийт судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийг бизнесийн салбараар ангилан харвал 19% нь худалдаа, 15% нь үйлчилгээ, 13% нь аялал жуулчлал, 9% нь хүнсний үйлдвэрлэл, 6% нь хөнгөн үйлдвэрлэлийн салбарын аж ахуй нэгжүүд байна. Судалгаанд оролцогсдын 40% нь 300 сая хүртэлх жилийн орлоготой бичил аж ахуй нэгжүүд, 39% нь 301 саяас 2.5 тэрбум төгрөгийн орлоготой жижиг, дунд аж ахуйн нэгжүүд, 21% нь 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой томоохон аж ахуйн нэгжүүд байгаа ба 51% нь 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулсан харьцангуй тогтворжсон аж ахуйн нэгжүүд хамрагджээ. Мөн ажиллагчдын тооны бүлгээр ангилан харвал 37% нь 10 хүртэлх ажилтантай, 53% нь 11-200 ажилтантай, 10% нь 201-ээс дээш ажилтантай байна.


### Бизнесийн салбараар




### Жилийн орлогын түвшингээр



### Бизнесийн насжилт



### Ажиллагчдын тооны бүлгээр



## **НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН 2020 ОНЫ ХАНДЛАГА**

- Хураангуй
- Ноолуурын зах зээлийн тойм
- Ноолуурын зах зээлийн үнэ ханшны таамаглал
- Ноолуурын аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн байдал, хэрэгцээ

**2020 оны 3 дугаар сарын 24**

## ХУРААНГУЙ

БНХАУ-аас эхлэн дэлхийд тархаад байгаа цар тахлын улмаас дэлхийн эдийн засаг өсөлт буурч, аялал жуулчлал, агаарын тээвэр, худалдаа үйлчилгээ гэсэн олон салбарын хувьд зогсонги байдалд ороод байна. Дэлхий эдийн засаг улам даяарчлагдаж, улс орнуудын эдийн засаг, нийлүүлэлтийн сүлжээний харилцан хамаарал урьд өмнөхөөс илүү болсон энэ үед эдийн засгийн хямрал өмнөхөөс илүү байх таамаглалыг олон улсын байгууллагууд, эдийн засагчид, судлаачид дэвшүүлж байна.

2019 оны байдлаар Монгол улсын угаасан ноолуурын 100 хувийг эзэлдэг БНХАУ, самнасан ноолуурын экспортын 85 хувийг эзэлсэн Итали улсын хувьд вирусийн халдварын улмаас эдийн засгийн өсөлт буурах төлөвтэй байна. Ялангуяа боловсруулсан ноолуурын зах зээлд голлох байр суурь эзэлдэг Европын орнууд, түүний дотор Итали, Англи, Герман улсын хувьд эдийн засаг буурахаар байна. БНХАУ 2018 онд самнасан ноолуурынхаа 60 орчим хувийг Итали улс руу экспортолсон байна.

2009 оны эдийн засгийн хямрал, 2015-2016 оны эдийн засгийн хүндрэлийн үед түүхий ноолуурын үнэ 24-25 хувиар, самнасан ноолуурын экспортын дундаж үнэ 30-31 хувь тус тус буурч байжээ.

Ноолуурын зах зээлийн индикатороос үзвэл 2018 оны 12 сарын 31-нээс хойш үнийн индекс тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны 1 сарын 29-ний байдлаар дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын өмнөх сараас 0.08-1.88 хувиар буурсан байна. Хятад, Иран, Монгол улсын индекс 1999, 2009-2010, 2016-2018 онуудад бууралттай байсан байна. ([www.gschneider.com](http://www.gschneider.com))

Ноолуурын эцсийн бүтээгдэхүүний дотоодын борлуулалт гадны жуулчдын худалдан авалт их нөлөөлдөг. 2020 оны хувьд аялал жуулчлалын салбар зогсонги байдалд орж, жуулчдын тоо эрс буурах хүлээлттэй байна.

МҮХАҮТ-аас “Ноолуурын салбарын аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн байдал, хэрэгцээ” судалгааг явуулж үүнд 55 аж ахуйн нэгж оролцсон. Судалгаанд оролцсон ААН-үүд нь 276.6 тонн түүхий ноолуур, 77 тонн угаасан ноолуур, 396 тонн самнасан ноолуур, 248.4 тонн утас, 992 мянган ширхэг бэлэн бүтээгдэхүүний нөөцтэй байна. Урьдчилсан тооцоогоор 2020 онд **3.7 мянган тонн** түүхий ноолуур шаардлагатай ба зарим ААН-үүд цар тахлын нөхцөл байдлаас эрэлт эрс буурсан учир одоогоор тооцох боломжгүй гэжээ. Түүхий ноолуурын дотоодын үнийн хувьд ААН-үүд-ийн 13% нь 50 мянга хүртэл, 41% нь 50-70 мянга, 28% нь 70-90 мянга, 18 хувь нь 90 мянган төгрөгөөс дээш байна гэсэн хүлээлттэй байна.

Цар тахлаас шалтгаалан тулгарах эдийн засгийн хямралыг 2009 оноос хойш тохиолдож байсан хямралуудын үр дагавартай адилхан тусна гэж өөдрөгөөр тооцоход 2020 онд түүхий ноолуурын дотоодын үнэ ойролцоогоор 60 мянган төгрөг байх тооцоо гарч байна.

## НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Дэлхийн ноолуурын зах зээлд жилд дунджаар 24 мянган тонн ноолуур бэлтгэдэг бөгөөд үүнээс БНХАУ дангаараа 12 мянган тонн ба 50%-ийг, Монгол улс 9,6 мянган тонн буюу 40%-ийг нийлүүлж байна. Ноолуур боловсруулах үйлдвэрлэлээр Итали, Их британи улсууд тэргүүлдэг.

Монгол улс нь 2019 онд 9,6 мянган тонн ноолуур бэлтгэсэн. 2009 оны байдлаар ноолуурын нийт экспортын 65.2 хувийг угаасан ноолуур, 10.4 хувийг самнасан ноолуур эзэлж байна. Гаалийн ерөнхий газрын мэдээнээс үзэхэд 5.7 мянган тонн, 283.3 сая ам.долларын өртөг бүхий угаасан ноолуурыг экспортолсон ба БНХАУ руу 100 хувь экспортолжээ. Самнасан ноолуурын экспортын хэмжээ 507 тонн, үнийн дүн 45.3 сая ам.доллар болсон бөгөөд үүний 85%-ийг Итали, 10%-ийг Их британи, 2%-ийг БНСУ, үлдсэн 3%-ийг бусад улс руу тус тус экспортолсон дүнтэй байна.

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Ноолуур хөтөлбөрийн хүрээнд 2018 онд 188.2 тэрбум төгрөг, 2019 онд 107.3 тэрбум төгрөгийг 12-14 хувийн хүүтэйгээр олгосон байна. ХХААХҮЯ-ны мэдээлснээс үзвэл 2018 онд самнах үйлдвэрийн хүчин чадал 28.6 хувь, сүлжих үйлдвэрлэлийн хүчин чадал 42.7 хувиар нэмэгдэж, 2019 онд 700 тонн самнах, 100 тонн зэрэх хүчин чадал нэмж суурилагджээ.

## НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ ХАНШНЫ ТААМАГЛАЛ

Шинэ корона вирусийн халдвар цар тахлын хэмжээнд хүрч, дэлхийн эдийн засгийн өсөлт буурч, эдийн засаг хямралын ирмэгт тулж ирснийг олон улсын байгууллагууд, томоохон эдийн засагтай орнуудын засгийн газрууд удаа дараа мэдэгдлээ.

Ноолуурын зах зээлд голлох байр суурь эзэлдэг БНХАУ, Итали, Их Британи, Герман зэрэг улсуудад эдийн засгийн өсөлт буурах нь тодорхой боллоо.

Ноолуурын зах зээлийн индикатороос үзвэл 2018 оны 12 сарын 31-нээс хойш индекс тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны 1 сарын 29-ний байдлаар өмнөх сараас 0.08-1.88 хувиар буурсныг дараах хүснэгтээс харж болно.


Origin	Date	Index value	Var.%
China	29/01/2020	121.25	-0.08
Iran	29/01/2020	85.00	-1.88
Mongolia	29/01/2020	96.60	-1.66

Эх үүсвэр: <https://www.gschneider.com/cashmere-and-silk-market-indicators/>

Ноолуурын зах зээлийн индикаторыг авч үзвэл Хятад, Иран, Монгол улсын индекс 1999, 2009-2010, 2016-2018 онуудад буурч байсан байна.



### Cashmere Market Indicators



Эх үүсвэр: <https://www.gschneider.com/cashmere-and-silk-market-indicators/>

Монгол улсын 2000-2009 онуудын самнасан ноолуурын экспортын хэмжээ, үнийн дүнгийн авч үзэхэд 2003, 2009, 2016-2017 онуудад буурсан дүнтэй байсан байна. Уг онуудад тоо хэмжээний хувьд өмнөх жилүүдээс бага хэмжээтэй буурсан үнийн дүн огцом буурчээ.



Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий Газар

2003 онд гарч байсан SARS – ын нөлөөгөөр самнасан ноолуурын экспортын хэмжээ, экспортын дундаж үнэ аль аль нь буурч байсан байна.

2008-2009 оны эдийн засгийн хямралын үед түүхий ноолуурын дотоодын үнэ 24 хувиар, угаасан ноолуурын экспортын дундаж үнэ 36 хувиар, самнасан ноолуурын экспортын дундаж үнэ 32 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

2015-2016 онд тохиолдсон эдийн засгийн хүндрэлийн нөхцөлд түүхий ноолуурын дотоодын үнэ 25 хувиар, угаасан ноолуурын экспортын дундаж үнэ 31 хувиар, самнасан ноолуурын дундаж үнэ 29 хувиар тус тус буурч гарсан байна.



Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий Газар, Үндэсний статистикийн Хороо

Монголын улсын түүхий болон боловсруулсан ноолуурын 2000-2019 оны үнэ, ноолуурын зах зээлийн үнийн индексээс харахад эдийн засгийн хямралаас шалтгаалан ноолуурын зах зээлийн эрэлт, ялангуяа үнэ ханш огцом буурч байсан нь харагдаж байна.

Цар тахлаас шалтгаалан тулгарах эдийн засгийн хямралыг 2009 оноос хойш тохиолдож байсан хямралуудтай ижил үр дагаварыг авчирна үзвэл 2020 онд түүхий ноолуурын дотоодын үнэ ойролцоогоор 60 мянган төгрөг байх тооцоо гарч байна. Энэнь одоо үүсээд байгаад нөхцөл байдалтай харьцуулбал өөдрөг төсөөлөл гэж хэлж болох бөгөөд цаашид энэ үнэ хэд хүртэл буурах талаар таамаглах боломжгүй байна.

## НООЛУУРЫН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ

МҮХАҮТ-аас 2020 оны 3 дугаар сард “Ноолуурын салбарын аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн байдал, хэрэгцээ” судалгааг явуулж үүнд 55 аж ахуйн нэгж оролцсон. Судалгаанд оролцсон ААН-үүдийн 70% нь сүлжих, 10% нь самнах, 7% нь ээрэх, 5% нь угаах, 8% нь бүх шатны үйлдвэрлэлийг явуулдаг бөгөөд 28% нь том, дунд аж ахуйн нэгжүүд, 72% нь жижиг, бичил аж ахуйн нэгж байна. Судалгааны үр дүнг тоймлон үзүүлбэл:

### Түүхий эд материалын нөөц


Судалгаанд оролцсон 55 ААН нь 276.6 тонн түүхий ноолуур, 77 тонн угаасан ноолуур, 396 тонн самнасан ноолуур, 248.4 тонн утас, 992 мянган ширхэг бэлэн бүтээгдэхүүний нөөцтэй байна.



Урьдчилсан тооцоогоор 2020 онд **3.7 мянган тонн** түүхий ноолуур шаардлагатай ба зарим ААН-үүд цар тахлын нөхцөл байдлаас эрэлт эрс буурсан учир одоогоор тооцох боломжгүй гэжээ.

### Ноолуур бэлтгэлийн үнэ ханшны хүлээлт

Түүхий ноолуурын дотоодын үнийг 2020 онд судалгаанд оролцогчдын 13% нь 50 мянган төгрөг хүртэл, 41% нь 50-70 мянган төгрөг, 46% нь 70 мянган төгрөгөөс дээш байна гэсэн хүлээлттэй байна.



## **ААН-үүдийн санхүүгийн байдал, хэрэгцээ**

ААН-үүдийн 83.3% нь зээлийн үлдэгдэлтэй ба нийт зээлийн үлдэгдлийн хэмжээ 259.3 тэрбум төгрөг байна. Зээлийн үлдэгдэлтэй ААН-үүдийн 31 хувь нь 8-12%-ийн, 52 хувь нь 12%-иас дээш хувийн хүүтэй зээлтэй байна.

Судалгаанд оролцсон **нийт ААН-ийн шаардлагатай санхүүжилтийн хэмжээ 360.3 тэрбум төгрөг** бөгөөд 91% нь санхүүжилт авах шаардлагатай гэсэн ба 56% нь хөнгөлттэй зээл, 33% нь арилжааны банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. **Санхүүжилтийн хэрэгцээний 27%-ийг эргэлтийн хөрөнгөнд, 20%-ийг машин тоног төхөөрөмж худалдан авах, 22%-ийг маркетинг, судалгаа, шинжилгээний зардалд, 16%-ийг шинээр ажлын байр бий болгох, ажиллагсадыг сургаж чадавхжуулахад зарцуулах төлөвлөгөөтэй гэжээ.**

Зээлийн хүүгийн тохиромжтой түвшинг 59% нь 3 хүртэлх хувь, 24% нь 3-5 хувь, 15 хувь нь 5-8 хувь гэж үзжээ.

## **ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨНИЙ СУДАЛГАА**

- Хураангуй
- Эм хангамжийн салбарт үзүүлж буй нөлөө
- Зайлшгүй байх ёстой эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц
- Шаардлагатай дэмжлэг

**2020 оны 3 дугаар сарын 27**

## ХУРААНГУЙ

МҮХАҮТ ба Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “ЭМ” холбоо хамтран вирусийн халдвараас сэргийлэх, тархалтыг хязгаарлах арга хэмжээний эм эмнэлгийн хэрэгслийн хангамжийн салбарт үзүүлж байгаа үр нөлөө ба шаардагдаж буй дэмжлэгийг тодорхойлох зорилгоор эм хангамжийн аж ахуйн нэгжүүдээс асуулгаар энэ судалгааг авсан. Эм эмнэлгийн хангамжийн үйлдвэрлэл, импорт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 60 гаруй байгууллагаас 42 нь тогтмол үйл ажиллагаатай байгаа ба үүнээс 34 компани энэхүү судалгаанд оролцсон болно.

Вирусийн халдвараас үүссэн нөхцөл байдал судалгаанд оролцогчдын 56 хувьд нь маш их нөлөөлсөн, 35 хувьд нь дунд зэрэг нөлөөлсөн байна. Эм, эмнэлгийн хангамжийн үйл ажиллагаа явуулахад эм, хэрэгсэл, эмийн түүхий эдийн үнэ өссөн, нийлүүлэлт хомсдсон, түүхий эдийн хомсдлоос үүдэн үйлдвэрлэл тасалдсан, нийлүүлэгч талаас төлбөрийг 100 хувь урьдчилан төлөх нөхцөл тавих болсон, тендерийн худалдан авалт дээр авлага үүссэн, эргэлтийн хөрөнгийн дутагдалд орсон зэрэг асуудлууд тулгарч байна гэж оролцогчдын 32-70 орчим хувь хариулсан байна. 70 хувь нь нийлүүлэгч талаас төлбөрийг 100 хувь урьдчилан төлөх нөхцөл тавих болсон гэсэн байна.

Эмийн нөөцийн хувьд 53 хувь нь 1-3 сарын, 29 хувь нь 1 сар хүртэл хугацааны нөөцтэй байгаа бөгөөд 15 хувь нь нөөцгүй болсон байна. Судалгаанд оролцогчдын 62 хувиас дээш нь нэг удаагийн маск, хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтлийн бодис тасалдсан, ирэх 3 сард ч тасалдалтай байна гэж үзжээ.

Эм хангамж, эмийн хэрэгслийн нийлүүлэлтийг тогтвортой байлгахад хөнгөлөлттэй зээл авах-79 хувь, зайлшгүй эм, эмийн түүхий эд хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх – 59-71 хувь, асуудал хариуцсан төрийн байгууллагаас зохицуулалт хийх-50 хувь, тендерийн худалдан авалт, ЭМДС дээр үүсэн авлагыг барагдуулах- 44-50 хувь гэсэн дэмжлэгүүд шаардлагатай гэжээ.


Эргэлтийн хөрөнгөнд шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ ААН дээр харилцан адилгүй гарсан бөгөөд 48 хувьд нь 51-500 сая, 21 хувьд нь 500 саяас 1 тэрбум, 18 хувьд нь 1 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилтийн хэрэгцээтэй гарсан бөгөөд оролцогчдын 12 хувь нь 50% дээш, 36 хувь нь 20-50%, 21 хувь нь санхүүжилтийн 20%-ийг өөрөөсөө гаргах боломжтой гэсэн байна.

Эм хангамжийн байгууллагуудад учирч байгаа нэг гол асуудал болох тендерийн худалдан авалт дээр үүссэн авлагын хувьд нийт ААН-ийн 76 хувь нь авлагатай гэсэн бөгөөд 15 хувь нь 1 тэрбум төгрөгөөс дээш, 12 хувь нь 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл, 50 хувь нь 250 сая төгрөг хүртэл авлагатай байна. Мөн оролцогчдын 68 хувь нь тендерийн гүйцэтгэлийн баталгаан дээр тодорхой хэмжээний мөнгө тавьсан нь эргэлтийн хөрөнгийн дутагдахад нөлөөлдөг гэж үзсэн ба 50 хувь нь 250 сая хүртэл, 15 хувь нь 250-500 сая, 6 хувь нь 500 саяас дээш төгрөгийг гүйцэтгэлийн баталгаанд байршуулсан байна.

Зайлшгүй шаардлагатай байх эм, эмийн түүхий эдийн 1 сарын нөөцийг бүрдүүлэхэд 11.3 тэрбум төгрөг, вирусийн халдвар хамгаалалтын арга хэмжээний үед зайлшгүй байх 6 бүлгийн 50 эмний нэг сарын нөөцийг бүрдүүлэхэд 16.7 тэрбум төгрөг, эмнэлгийн болон хамгаалах хэрэгслийн нэг сарын нөөцөнд 9.1 тэрбум төгрөг, нийт 37.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэсэн байна.

## ЭМ ХАНГАМЖИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Covid-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээ нөлөөний талаар судалгаанд оролцогсдын 56% нь маш их, 35% нь дунд зэрэг нөлөөлсөн, 9% нь одоо хэлэхэд эрт байна, 0% нь нөлөөлөөгүй гэсэн хариулсан.




Эм, эмнэлгийн хангамжийн үйл ажиллагаа явуулахад эм, хэрэгсэл, эмийн түүхий эдийн үнэ өссөн, нийлүүлэлт хомсдсон, түүхий эдийн хомсдлоос үүдэн үйлдвэрлэл тасалдсан, нийлүүлэгч талаас төлбөрийг 100 хувь урьдчилан төлөх нөхцөл тавих болсон, тендерийн худалдан авалт дээр авлага үүссэн, эргэлтийн хөрөнгийн дутагдалд орсон зэрэг асуудлууд тулгарч байна гэж оролцогчдын 32-70 орчим хувь хариулсан байна. 70 хувь нь нийлүүлэгч талаас төлбөрийг 100 хувь урьдчилан төлөх нөхцөл тавих болсон гэсэн байна.



### Эм хангамжийн нөөц

Эмийн нөөцийн хувьд 53 хувь нь 1-3 сарын, 29 хувь нь 1 сар хүртэл хугацааны нөөцтэй байгаа бөгөөд 15 хувь нь нөөцгүй болсон байна. Судалгаанд оролцогчдын 62 хувиас дээш нь нэг удаагийн маск, хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис тасалдсан, ирэх 3 сард ч тасалдалтай байна гэж үзжээ.



### ЗАЙЛШГҮЙ БАЙХ ЁСТОЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН НӨӨЦ

Вирусийн халдварын тархалтаас хамгаалах арга хэмжээний онцгой үетэй холбоотой эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээ болон энгийн горимын үед суурь өвчтэй өвчтөнүүд тогтмол хэрэглэдэг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн одоогоор тасалдсан байдал ба ойрын 3 сард байлгах ёстой нөөцийн талаар судалгааны оролцогчдоос тодруулсан.


Вирусийн халдварын үед хэрэглэгдэх 8 бүлгийн 21 эм (Хавсралт 1), 10 төрлийн эмнэлгийн төхөөрөмж, 8 төрлийн хамгаалалтын хувцас хэрэглэл, 3 төрлийн ариутгалын бодис (Хавсралт 2) тасарсан буюу нөөц эрс багассан байна. Энгийн үед зайлшгүй байх эмийн нөөцийн хувьд 4 бүлгийн 18 эм (Хавсралт 3), 14 төрлийн эмнэлгийн хэрэгсэл (Хавсралт 4) тасалдсан байна.

Ойрын 3 сард 6 бүлгийн 57 эм, 2 түүхий эдийн (Хавсралт 5) нөөц бүрдүүлэх шаардлагатай байгаагаас антибиотик, вирусийн эсрэг эм, цус сэлбэх бэлдмэлд онцгой анхаарах шаардлагатай байна. Эмнэлгийн хэрэгсэлд 7 төрлийн бүтээгдэхүүний нөөцийг ойрын 3 сард бүрдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд халуун хэмжигч, зүү, гемодиализийн шүүлтүүрийн . (Хавсралт 6) хангамжийг анхаарах хэрэгтэй байна.

### ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ

Эм хангамж, эмийн хэрэгслийн нийлүүлэлтийг тогтвортой байлгахад хөнгөлөлттэй зээл авах 79 хувь, зайлшгүй эм, эмийн түүхий эд хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх 59-71 хувь, асуудал хариуцсан төрийн байгууллагаас зохицуулалт хийх 50 хувь, тендерийн худалдан авалт, ЭМДС дээр үүсэн авлагыг барагдуулах 44-50 хувь гэсэн дэмжлэгүүд шаардлагатай гэжээ.





Вирусийн халдвараас урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн засгийн газрын үйл ажиллагаанд эм хангамжийн байгууллагын нийт оролцогчдын 50 гаруй хувь нь эм биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хамгаалах хэрэгсэл, амны хаалт, эмнэлгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна.

### Санхүүгийн хэрэгцээ

Эргэлтийн хөрөнгөнд шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ ААН дээр харилцан адилгүй гарсан бөгөөд 48 хувьд нь 51-500 сая, 21 хувьд нь 500 саяас 1 тэрбум, 18 хувьд нь 1 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилтийн хэрэгцээтэй гарсан.

Оролцогчдын 12 хувь нь 50% дээш, 36 хувь нь 20-50%, 21 хувь нь санхүүжилтийн 20%-ийг өөрөөсөө гаргах боломжтой гэсэн байна.

Эм хангамжийн байгууллагуудад учирч байгаа нэг гол асуудал болох тендерийн худалдан авалт дээр үүссэн авлагын хувьд нийт ААН-ийн 76 хувь нь авлагатай гэсэн бөгөөд 15 хувь нь 1 тэрбум төгрөгөөс дээш, 12 хувь нь 500 саяас 1 тэрбум төгрөг хүртэл, 50 хувь нь 250 сая төгрөг хүртэл авлагатай байна. Мөн оролцогчдын 68 хувь нь тендерийн гүйцэтгэлийн баталгаан дээр тодорхой хэмжээний мөнгө тавьсан нь эргэлтийн хөрөнгийн дутагдахад нөлөөлдөг гэж үзсэн ба 50 хувь нь 250 сая хүртэл, 15 хувь нь 250-500 сая, 6 хувь нь 500 саяас дээш төгрөгийг гүйцэтгэлийн баталгаанд байршуулсан байна.

Зайлшгүй шаардлагатай байх эм, эмийн түүхий эдийн 1 сарын нөөцийг бүрдүүлэхэд 11.3 тэрбум төгрөг, вирусийн халдвар хамгаалалтын арга хэмжээний үед зайлшгүй байх 6 бүлгийн 50 эмний нэг сарын нөөцийг бүрдүүлэхэд 16.7 тэрбум төгрөг, эмнэлгийн тоног төхөөрөмж болон хамгаалах хэрэгслийн нэг сарын нөөцөнд 9.1 тэрбум төгрөг, **нийт 37.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй** байна.

## ХАВСРАЛТ

Хавсралт 1. Covid-19 халдварын хамгаалалтын арга хэмжээний үед зайлшгүй байх тасалдаж байгаа эмийн нөөц

№	Covid-19 халдварын хамгаалалтын арга хэмжээний үед зайлшгүй байх тасалдаж байгаа эмийн нөөц	
1	1. Ариутгалын бодис	1 Жавелин
2	2. Түүхий эд	2 Аскорбины хүчил
3	3. Дархлаа дэмжих	3 Алое
4	4. Вирусийн эсрэг эм	1 осельтамивир
5		2 Рибаварин
6		3 Ацикловир
7		4 Арбидол
8	5. Антибиотик	5 Рибоварин
9		1 Добутамин
10		2 цефатоксим
11		3 Эритромицин 0,5
12	4 Ампициллин	
13	6. Үрэвсэл намдаах, халуун бууруулах	1 диклофенак
14		2 Анальгин
15	7. Цус сэлбэх шингэн	1 Натрийн хлорид 0.9%
16		2 Рингер лактат
17	8. Бусад бүлгийн эмүүд, зориулалт	1 Аминокапраны хүчил
18		2 Септилин
19		3 Фурсомед
20		4 магни сульфат
21		5 Димедрол

Хавсралт 2. Covid -19 халдварын хамгаалалтын арга хэмжээний үед зайлшгүй байх эмнэлгийн болон хамгаалах хэрэгслийн нөөц

№	Covid -19 халдварын хамгаалалтын арга хэмжээний үед зайлшгүй байх эмнэлгийн болон хамгаалах хэрэгслийн нөөц	
1	1. Эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл	1 Амьсгалын аппарат
2		2 Хүчилтөрөгчийн аппарат
3		3 Гемодиализийн шүүлтүүр
4		4 ЕСМО аппарат хэрэгсэл
5		5 сорох аппарат
6		6 зайнаас халуун хэмжигч
7		7 халуун хэмжигч
8		8 төрөл бүрийн катетерүүд
9		9 гуурс зүү
10		10 тариур
11	2. Халдвар хамгааллын хувцас	1 малгай
12		2 нэг удаагийн нүүрний хаалт
13		3 хамгаалалтын шил
14		4 N95 маск
15		5 хамгааллын хувцас
16		6 бээлий
17		7 халат
18		8 гутал
19	3. Ариутгалын бодис	1 хлорамин
20		2 жавелин
21		3 гар ариутгагч
22	4. Бусад	1 сав баглаа боодол

Хавсралт 3. Зайлшгүй шаардлагатай тасалдал үүссэн эм

№	Зайлшгүй шаардлагатай тасалдал үүссэн эм	
1	1. Дархлаа дэмжих	1 салимон
2		2 алое
3	2. Вирусийн эсрэг эм	1 гроприносин
4		2 ацикловир
5		3 амизон
6		4 цефазолин
7		5 цефтриаксон
8		6 цефатоксим
9	3. Үрэвсэл намдаах, халуун бууруулах	1 парацетамол
10		2 диклофенак
11		3 анальгин
12	4. Цус сэлбэх шингэн	1 натрийн хлорид 0.9%
13		2 рингер лактат
14	5. Бусад	1 дигоксин
15		2 инсулин
16		3 морфин
17		4 магни сульфат
18		5 сахарын эм

Хавсралт 4. Тасалдсан эмнэлгийн хэрэгсэл

№	Тасалдсан эмнэлгийн хэрэгсэл
1	Гемодиализын шүүлтүүр гуурс зүү.
2	Спирттэй арчдас
3	Хүчилтөрөгчийн аппарат
4	Хүчилтөрөгчийн гуурс
5	Тариур мэс заслын утас, уян зүү, нугасны хатгалтын зүү тариур
6	Амьсгалын аппарат
7	Стент,
8	Баллоон
9	Утлаганы аппарат-
10	Халууны шил, зайнаас халуун хэмжигч
11	Санитол түүхий эд

Хавсралт 5. Ойрын 3 сард нөөц бүрдүүлэх эм, түүхий эдийн жагсаалт

№	Хомсдол үүсч болзошгүй эм, түүхий эдийн жагсаалт	
1	1. Дархлаа дэмжих	1 витарипп
2		2 салимон
3		3 Алое
4	2. Вирусийн эсрэг эм	1 Гроприносин
5		2 рибаварин
6		3 ацикловир
7		4 арбидол
8	3. Антибиотик	1 ципрофлоксацин
9		2 кларитромицин
10		3 азитромицин
11		4 Амоксициллин-Клавулон хүчил 675 мг шахмал
12		5 Добутамин
13		6 Цефазолин
14		7 цефтриаксон
15		8 цефатоксим

16		9	Эритромицин 0,5
17		10	Ампициллин
18	4. Үрэвсэл намдаах, халуун бууруулах	1	парацетамол
19		2	ибупрофен
20		3	Кетотифен
21		4	диклофенак
22		5	Реналган
23		6	Мупироцин тос
24		7	Анальгин
25	5. Цус сэлбэх шингэн	1	Натрийн хлорид 0.9%
26		2	Рингер лактат
27	6. Бусад бүлгийн эмүүд, зориулалт	1	Ингавир 90мг шахмал
28		2	Аминокапраны хүчил
29		3	дигоксин
30		4	Септилин
31		5	Гепарин
32		6	Кол кол эс №10
33		7	Бэби күүл күүл
34		8	инсулин
35		9	морфин
36		10	трамадол
37		11	Фурсомед
38		12	магни сульфат
39		13	Декостриол
40		14	Димедрол
41		15	Норадреналин
42		16	сахарын эм
43		17	үрэвслийн эсрэг
44		18	цус бүлэгнүүлэх эм
45		19	зүрхний гликозид
46		20	халдварын эсрэг эм
47		21	Цус бүлэгнэлтийн эсрэг эм
48		22	ханиалга намдаах эм
50		23	даавар
51		24	өвчин намдаах эм
52		25	шээс хөөх эм
53		26	даралт бууруулах, агчилт тавиулах
54		27	Вид ДЗ-ын метаболит
55		28	нойрсуулах, тайвшруулах
56		29	титэм судас өргөсгөх эм
58	7. Дааврийн эм	1	Гональ
60		2	Крайнон
61		3	Перговорис
62		4	Овитрелле
63		5	Прогинова
64		6	Dostinex
65		7	Decapeptyl
66	8. Түүхий эд	1	Техникийн болон дээд спирт
67		2	Аскорбины хүчил

Хавсралт 6. Ойрын 3 сард нөөц бүрдүүлэх эмнэлгийн хэрэгсэл

№	Эмнэлгийн хэрэгсэл
1	Гемодиализийн шүүлтүүр
2	гуурс зүү
3	хамгаалалтын шил
4	бээлий
5	зайнаас халуун хэмжигч
6	сорох аппарат
7	нэг удаагийн нүүрний хаалт